



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 05 дугаар сарын 13
№ 20 /929/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1418

Монгол Улсын
Их Хурлын
тогтоол

1444

**Боловсролын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай**

**Монгол Улсын Их Хурлын
сонгуулийн тойрог байгуулах,
тойргийн мандатын тоо, дугаар,
нутаг дэвсгэр, төвийг тогтоох
тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | |
|------|---|------|
| 469. | Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1418 |
| 470. | Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1430 |
| 471. | Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1437 |
| 472. | Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай | 1440 |
| 473. | Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1441 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | | |
|------|--|-----------|------|
| 474. | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай | Дугаар 41 | 1444 |
|------|--|-----------|------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|------|--------------------|------------|------|
| 475. | Журам батлах тухай | Дугаар 153 | 1452 |
|------|--------------------|------------|------|

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

| | | | |
|------|---|-----------|------|
| 476. | Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 06 | 1461 |
|------|---|-----------|------|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.16-3.1.20 дахь заалт:

“3.1.16.“ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага” гэж сургалтын үйл ажиллагаа явуулах үндсэн зорилготой, үйл ажиллагаанаасаа олсон ашгийг /орлогыг/ зөвхөн үндсэн зорилгын дагуу зарцуулдаг, үндсэн хөрөнгө нь хувьцаанд хуваагддаггүй хуулийн этгээдийг;

3.1.17.“ашгийн төлөө боловсролын сургалтын байгууллага” гэж хувь оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилдаг бөгөөд ашиг олох зорилгоор сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;

3.1.18.“сургалтын цөм хөтөлбөр” гэж тухайн шатанд суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвлөлийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичгийг;

3.1.19.“өдөр өнжүүлэх үйлчилгээ” гэж эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу сургалтын байгууллага иргэнтэй харилцан тохиролцож үйлдсэн гэрээний үндсэн дээр эрүүл, аюулгүй орчинд хүүхдийг асрах, хамгаалах, хөгжлийг дэмжих сургалтаас гадуур үзүүлэх үйлчилгээг;

3.1.20.“насан туршийн боловсрол” гэж бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг.”

2/9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг:

“9.5.Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан тооцох

асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.”

3/10 дугаар зүйлийн 10.2, 10.3 дахь хэсэг:

“10.2.Тухайн шатны боловсролын агуулгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хөтөлбөрөөр зохион байгуулна.

10.3.Бүх шатны боловсролын хөтөлбөрт монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, гэр бүл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, суралцагчийн гүйцэтгэх сайн дурын үйл ажиллагааны төрөл, агуулгыг заавал тусгаж, музей, номын сан, кино зэрэг соёл, урлаг, спортын байгууллагын боломжийг ашиглахаар зохион байгуулна.”

4/11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг:

“11.5.Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан батална.”

5/12 дугаар зүйлийн 12.3-12.5 дахь хэсэг:

“12.3.Төрийн өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус байна.

12.4.Төрийн бус өмчид түшиглэн байгуулах боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус болон ашгийн төлөө байна.

12.5.Ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө боловсролын сургалтын байгууллага байгуулахыг хориглоно.”

6/16 дугаар зүйлийн 16.6, 16.7 дахь хэсэг:

“16.6.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага боловсролын хөгжлийн бодлого болон сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйлчилгээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.



16.7.Багшийн мэргэжил дээшлүүлэх, арга зүйн байгууллагын дүрэм, бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон тоог санхүү, төсвийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.”

7/18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг:

“18.5.Энэ хуулийн 3.1.19-т заасан үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

8/21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэг:

“21.6.Боловсролын сургалтын байгууллага шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагаар урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэнэ.”

9/22 дугаар зүйлийн 22.2-22.4 дэх хэсэг:

“22.2.Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь журмаар олгоно:

22.2.1.тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 21.1-д заасан баримт бичгийг үүсгэн байгуулагчаас хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор боловсролын сургалтын байгууллага байгуулах урьдчилсан зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх;

22.2.2.урьдчилсан зөвшөөрөл олгох тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан өдрөөс үүсгэн байгуулагч тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангах талаар санал болгосон нөхцөлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

22.2.3.үүсгэн байгуулагч тусгай зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа холбогдох баримт бичгийг өргөдлийн хамт эрх бүхий байгууллагад ирүүлэх;

22.2.4.тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор эрх бүхий байгууллага төрийн захиргааны болон боловсролын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий шинжээчийн хэсэг томилж, магадлан

шинжилгээ хийлгэх бөгөөд магадлан шинжилгээ хийлгэхтэй холбогдсон зардлыг үүсгэн байгуулагч хариуцах;

22.2.5. шинжээчийн хэсэг томилогдсоноосоо хойш 30 хоногт багтаан баримт бичигт магадлан шинжилгээ хийж, газар дээр нь танилцан дүгнэлт гаргах;

22.2.6. энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан байгууллага шинжээчийн хэсгийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэр гаргаж, үүсгэн байгуулагчид мэдэгдэх, тусгай зөвшөөрлийг олгох.

22.3. Боловсролын сургалтын байгууллага үүсгэн байгуулах гэрээ, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулсан, оршин байгаа газраа өөрчилсөн бол энэ тухайгаа улсын бүртгэлийн байгууллагад ажлын 15 өдрийн дотор бичгээр мэдэгдэж, улсын бүртгэлд өөрчлөлт оруулна.

22.4. Улсын бүртгэлийн байгууллага боловсролын сургалтын байгууллагыг сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд үндэслэн төрийн өмчийн, ашгийн төлөө бус, ашгийн төлөө гэсэн ангиллаар, энэ хуулийн 14, 14¹, 15 дугаар зүйлд заасан хэв шинжээр нь нэрлэж бүртгэнэ”.

10/24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалт:

“24.1.4. боловсролын сургалтын байгууллагыг бусад байгууллагатай нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулсан;”

11/25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсэг:

“25.6. Энэ хуулийн 25.2-т заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой дүгнэлт гаргах аргачлал, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

12/26 дугаар зүйлийн 26.5-26.8 дахь хэсэг:

“26.5. Боловсролын сургалтын байгууллагыг магадлан итгэмжлэх байгууллага нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл байна.



26.6.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл магадлан итгэмжлэх шалгуур, журмыг тогтоох, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хийх байгууллагыг бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

26.7.Төрөөс боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлд бусад магадлан итгэмжлэх байгууллагыг удирдамж, нэгдсэн зохицуулалтаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

26.8.Монгол Улсад магадлан итгэмжлэх үйл ажиллагаа явуулах гадаадын байгууллагыг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл бүртгэж, зөвшөөрөл олгоно.”

13/28 дугаар зүйлийн 28.1.26, 28.1.27 дахь заалт:

“28.1.26.гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншил зааж сургахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

28.1.27.ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, албан тушаалтанд тавих нийтлэг шаардлага, ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт батлах.”

14/28¹ дүгээр зүйлийн 28¹.1.10 дахь заалт:

“28¹.1.10.өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах.”

15/35 дугаар зүйлийн 35.4.9-35.4.11 дэх заалт:

“35.4.9.сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх, зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх;

35.4.10.сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөв, сангийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах, мэдээлэх;

35.4.11.сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг гаргаж, хамт олны хуралд тайлагнах.”



16/36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсэг:

“36.14.Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлтэй холбогдсон харилцааг Дээд боловсролын тухай хуулиар зохицуулна.”

17/39 дүгээр зүйлийн 39.14 дэх хэсэг:

“39.14.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг үр дүн, гүйцэтгэлд суурилан гэрээний дагуу улсын төсвөөс зардлын тодорхой хувийг санхүүжүүлэх бөгөөд үйлчилгээний төлбөрийн хэмжээг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөл тогтооно.”

18/41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг:

“41.4.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, ёс заншил, соёлын чиглэлээр суурь чадамж эзэмшүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа байгууллагад төрөөс дэмжлэг үзүүлж болох бөгөөд дэмжлэг үзүүлэх нөхцөл, шаардлага, хэмжээг Засгийн газрын баталсан журмаар зохицуулна.”

19/42 дугаар зүйлийн 42.9 дэх хэсэг:

“42.9.Дээд боловсролын сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зориулалтын барилга байгууламж, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн орчин, лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн, дотуур байраар хангах ажлыг Удирдах зөвлөл хариуцна.”

20/46 дугаар зүйлийн 46.2.5, 46.2.6 дахь заалт:

“46.2.5.боловсрол эзэмшихэд нь хүүхэддээ байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлэх, урамшуулан дэмжих;

46.2.6.хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяасыг хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааны үйл явц, үр дүнтэй танилцах.”

21/46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг:

“46.3.Хүүхдийнхээ суралцах, төлөвших, авьяас, чадварыг хөгжүүлэх асуудлаар боловсролын сургалтын байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж болно.”



2 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн Хоёрдугаар бүлэг, 10 дугаар зүйлийн гарчгийн “Боловсролын” гэсний дараа “хөтөлбөр,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “үнэлгээний” гэсний дараа “, мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “ерөнхий боловсролын сургууль,” гэсний дараа “цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний,” гэсний дараа “консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/,” гэж, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “дүүрэгт” гэсний дараа “насан туршийн болон” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “туслалцаа” гэсний дараа “, өдөр өнжүүлэх үйлчилгээ” гэж, 28¹ дүгээр зүйлийн 28¹.1.4 дэх заалтын “хяналт тавих,” гэсний дараа “хяналт-шинжилгээ хийх” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага,” гэсний дараа “төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль,” гэж, мөн хэсгийн “улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг ерөнхий боловсролын сургуульд” гэсний дараа “, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулсан боловсролын сургалтын байгууллагад” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг:

“11.4.Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллага дагаж мөрдөнө.”

2/12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг:

“12.2.Боловсролын сургалтын байгууллага ашгийн төлөө бус, эсхүл ашгийн төлөө байж болно.”

3/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын бүтэц, дүрэм болон аймаг, нийслэлийн боловсролын газрын ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

4/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:

“17.1.Насан туршийн боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага орон нутгийн насан туршийн болон албан бус боловсролын

байгууллагыг нэгдсэн удирдлага, бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ чиглэлээр боловсрол олгож байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг эрхэлнэ.”

5/17¹ дүгээр зүйлийн 17^{1.1}, 17^{1.2} дахь хэсэг:

“17^{1.1}.Боловсролын үнэлгээний байгууллага бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх, сургалт зохион байгуулах, дээд боловсролын хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн.

17^{1.2}.Боловсролын үнэлгээний байгууллагын бүтэц, дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

6/18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:

“18.3.Аж ахуйн нэгж, байгууллага боловсролын сургалтын болон сургалтын бусад байгууллагыг хууль тогтоомжид заасны дагуу байгуулан ажиллуулж болно.”

7/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2.Олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургууль, ерөнхий боловсролын лаборатори сургууль, их сургууль, дээд сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулах хамтарсан сургууль болон гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг, сургууль байгуулах тусгай зөвшөөрлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.”

8/23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“23.1.Тусгай зөвшөөрлийг 5 жилээс доошгүй хугацаагаар олгоно.”

9/25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт:

“25.1.1.ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага бол тухайн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн шийдвэрээр, ашгийн төлөө боловсролын сургалтын байгууллага бол хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр;”



10/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:

“25.2.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хуулийн 25.1.1-д заасны дагуу татан буулгах шийдвэр гарахаас 2 сарын өмнө тухайн боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах ажлын төлөвлөгөө, авах арга хэмжээний талаархи саналаа холбогдох тооцоо, судалгааны хамт боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх бөгөөд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг саналыг судлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.”

11/26 дугаар зүйлийн 26.1, 26.2 дахь хэсэг:

“26.1.Боловсролын магадлан итгэмжлэл нь боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хараат бус үнэлгээ хийж, ахиц дэвшлийг дэмжин, мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрөх ажиллагаа мөн.

26.2.Боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон, ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.”

12/26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг:

“26.4.Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын удирдах зөвлөл төр, олон нийт, суралцагчийн төлөөллөөс бүрдэнэ.”

13/28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт:

“28.1.2.боловсролын салбарын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, үзэл баримтлал, үндсэн чиглэл, дүрэм, журам, хөтөлбөр, төсөл, заавар, аргачлалыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;”

14/28 дугаар зүйлийн 28.1.8 дахь заалт:

“28.1.8.боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах;”



15/28 дугаар зүйлийн 28.1.19 дэх заалт:

“28.1.19.төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллеж, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын алба, насан туршийн боловсролын сургалт, арга зүйн байгууллага, төрийн өмчийн олон улсын хөтөлбөрийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирал /дарга/-ын ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх;”

16/28 дугаар зүйлийн 28.1.22 дахь заалт:

“28.1.22.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын байгууллагын багш, ажилтны ажлыг үнэлэх, дүгнэх, багшлах эрх олгох, арга зүйч, багш, сургалтын менежерийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журмыг батлах бөгөөд албан тушаал өөрчлөгдөх тохиолдолд цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаал эрхэлж байгаа багшийн мэргэжлийн зэрэг хэвээр хадгалагдах;”

17/30 дугаар зүйлийн 30.1.11 дэх заалт:

“30.1.11.аймаг, нийслэлийн боловсролын газрын даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрснөөр томилох, чөлөөлөх;”

18/35 дугаар зүйлийн 35.4.1 дэх заалт:

“35.4.1.сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;”

19/37 дугаар зүйл:

“37 дугаар зүйл.Боловсролын хяналт

37.1.Боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ.

37.2.Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина.”

20/40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг:



“40.2.Төрийн өмчит бүх шатны сургууль, цэцэрлэгийн тогтмол зардал, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрны нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.”

21/48 дугаар зүйлийн 48.2.1- 48.2.9 дэх заалт:

“48.2.1.энэ хуулийн 9 дүгээр зүйлийг зөрчиж боловсролын баримт бичгийг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн, ашигласан иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, хуурамч баримт бичгийг хураах;

48.2.2.энэ хуулийн 47.2-т заасан үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

48.2.3.ажил үүргээ гүйцэтгэхэд нь багшид санаатайгаар саад учруулсан, багшийн нэр хүндийг гутаан доромжилсон этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

48.2.4.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл аваагүй, боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн бол сургалтын төлбөрийг суралцагчид буцаан олгож, иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгож, олсон орлогыг хурааж, боловсролын сургалтын үйл ажиллагааг зогсоох;

48.2.5.энэ хуулийн 46.2.3-т заасан үүргийг хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

48.2.6. суралцагчийн бие махбодид халдсан, сэтгэл санааны дарамт үзүүлсэн, мөнгө өгөх, ном, бүтээгдэхүүн худалдаж авахыг тулгасан, тэдний хувийн нууцыг задруулсан, хуульд заагаагүй төлбөр, хураамж авсан нь баримтаар тогтоогдсон багш, ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

48.2.7. стандарт болон боловсролын сургалтын байгууллагад тавих шаардлагыг зөрчсөн удирдах албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

48.2.8. удирдах ажилтны болон багшийн ёс зүйг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон бол багшлах эрхийг хасах хүртэл арга хэмжээг авах;

48.2.9. байгууллагад хандивласан хөрөнгийг санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаагүй, зориулалтын бусаар зарцуулсан албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.”

4 дүгээр зүйл. 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “Албан бус” гэснийг “Насан туршийн болон албан бус” гэж, 22 дугаар зүйлийн гарчгийн “Улсын бүртгэлд бүртгэх” гэснийг “Тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх” гэж, 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллага” гэснийг “Ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн хэсгийн “дүрэм, үүсгэн байгуулагчтай байгуулсан гэрээнд” гэснийг “дүрэмд” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “хувьсах зардлын дундаж нормативыг” гэснийг “хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг” гэж, 40 дүгээр зүйлийн 40.8 дахь хэсгийн “мэргэжлийн зэрэг, ур чадварыг” гэснийг “мэргэжлийг” гэж, 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсгийн “Боловсролын сургалтын байгууллагыг” гэснийг “Ашгийн төлөө бус боловсролын сургалтын байгууллагыг” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалтын дугаарыг “24.1.5.” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.26 дахь заалтын дугаарыг “28.1.28” гэж, 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийн “Боловсролын сургалтын байгууллага” гэснийг “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.



5 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Албан сургалт нь өдөр, орой, эчнээ, экстернат зэрэг хэлбэртэй байж болно.” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “боловсролын улсын стандартаар нарийвчлан” гэснийг, мөн зүйлийн 11.2 дахь хэсгийн “суралцагчийн зайлшгүй эзэмшсэн байвал зохих боловсролын агуулгын түвшин, түүний үнэлгээ,” гэснийг, мөн зүйлийн 11.3 дахь хэсгийн “Боловсролын” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “болон аймаг, нийслэлийн боловсролын газар” гэснийг, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “аттестатчиллын үнэлгээ болон” гэснийг, мөн заалтын “боловсролын” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.12 дахь заалтын “төрийн өмчит их сургууль, дээд сургууль, коллеж,” гэснийг, 28¹ дүгээр зүйлийн 28¹.1.4 дэх заалтын “аттестатчилах” гэснийг, 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсгийн “хөнгөлөлттэй” гэснийг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсгийн “, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын хяналтын улсын байцаагч” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл.Боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийг, 28 дугаар зүйлийн 28.1.21 дэх заалтыг, мөн зүйлийн 28.2 дахь хэсгийг, 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалтыг, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Дээд боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг:

“4.5.Дээд боловсролын зэрэг олгодог онолын мэдлэг, ур чадвар, дадал бүхий үйлдвэрийн инженер, технологичийг бэлтгэх технологийн коллеж байх бөгөөд технологийн коллежийн хөтөлбөрийн агуулга, багц цагийн хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”

2/6 дугаар зүйлийн 6.8, 6.9 дэх хэсэг:

“6.8.Татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулах хугацаандаа гаргасан тушаал шийдвэр, суралцагчдын нэрс, төгсөгчдийн дипломын хуулбар, сургалтын төлөвлөгөө зэрэг сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг татан буугдах шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Үндэсний төв архивт хүлээлгэн өгнө.

6.9.Татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллага төгсөлт хийгээгүй суралцагчийг өөр сургуульд шилжүүлэхдээ түүнийг сургуульд анх элсүүлсэн тушаал шийдвэр, судалсан хичээл, шалгалттай холбоотой материалыг шилжүүлсэн шийдвэрийн хамт шилжин очих сургуулийн захиргаанд хүлээлгэн өгнө.”

3/8 дугаар зүйлийн 8.11, 8.12 дахь хэсэг:

“8.11.Дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын магадлан итгэмжлэл хийх эрх бүхий байгууллагаар байгууллагын магадлан итгэмжлэлийг заавал хийлгэнэ.

8.12.Дээд боловсролын сургалтын байгууллага хөтөлбөрөө сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлнэ.”

4/11¹, 11² дугаар зүйл:**“11¹ дүгээр зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл**

11¹.1.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 30 хувь, төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 60 хувь нь тус тус үүсгэн байгуулагчийн төлөөлөл байх бөгөөд төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд орох төлөөллийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.

11¹.2.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 40 хувь, төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын 10 хувь нь 6 жилийн хугацаатай томилогдсон хараат бус гишүүд байх бөгөөд удирдах зөвлөлийг анх байгуулахад хараат бус гишүүдийг үүсгэн байгуулагч томилж, түүнээс хойш шинээр томилох гишүүнийг удирдах зөвлөлөөс байгуулсан хороо



нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу тодруулна.

11^{1.3}. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 20 хувь нь багш, оюутны төлөөлөл байх бөгөөд багшийн төлөөллийг 2 жилээр, оюутны төлөөллийг 1 жилээр хамт олны хурлаас тус тус сонгоно.

11^{1.4}. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 10 хувь нь төгсөгчдийн төлөөлөл байх бөгөөд тухайн боловсролын сургалтын байгууллагын дүрмийн дагуу байгуулагдсан төгсөгчдийн байгууллагын шийдвэрээр 3 жилийн хугацаатай томилно.

11^{1.5}. Удирдах зөвлөл нь дарга, нарийн бичгийн даргатай байх бөгөөд тэдгээрийг удирдах зөвлөлөөс 3 жилийн хугацаатай томилно.

11^{1.6}. Удирдах зөвлөл нь Боловсролын тухай хуулийн 36.11-д заасан чиг үүргээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11^{1.6.1}. дээд боловсролын сургалтын байгууллагын хотхон, барилга байгууламжийн төлөвлөлт, засвар, шинэ барилга байгууламжийн хэрэгцээг тогтоох;

11^{1.6.2}. дээд боловсролын сургалтын байгууллагын захирлыг томилох, чөлөөлөх;

11^{1.6.3}. дээд боловсролын сургалтын байгууллагын багц цагийн төлбөр болон үйлчилгээний бусад хураамжийн хэмжээг тогтоох.

11² дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгох

11^{2.1}. Төрийн өмчийн болон ашгийн төлөө бус дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл нь тухайн боловсролын сургалтын байгууллагын захиралд нэр дэвшигчийг тодруулах “Нэр дэвшүүлэх хороо”-г байгуулна.

11^{2.2}. Удирдах зөвлөл нь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын захиралд тавих нэмэлт шаардлагыг тодорхойлж, батална.



11².3.Нэр дэвшүүлэх хороо нь энэ хуулийн 11².4-т заасан шаардлагад нийцсэн хүнийг тодруулах, нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулалт зохион байгуулах үүрэгтэй бөгөөд сонгон шалгарсан хүнийг удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

11².4.Захирлын албан тушаалд нэр дэвшигч нь төрийн улс төрийн албан тушаал хашдаггүй, дээд боловсролын тухайн сургалтын байгууллагыг удирдах мэдлэг, чадвар, туршлагатай иргэн байна.”

5/11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг:

“11.7.Ашгийн төлөө дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлагыг Компанийн тухай хуулиар зохицуулна.”

6/12 дугаар зүйлийн 12.1.14, 12.1.15 дахь заалт:

“12.1.14.дээд боловсролтой хүмүүсийг дахин мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, ерөнхий боловсролын болон богино хугацааны сургалт эрхлэх;

12.1.15.хуульд заасан бусад эрх, үүрэг.”

7/12 дугаар зүйлийн 12.2-12.4 дэх хэсэг:

“12.2.Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор их сургууль, дээд сургууль нь өөрийн үндсэн бүтцэд харьяалагдах сургалт-судалгааны бизнес-инкубатор, технологи дамжуулах төвийг дангаар болон үйлдвэрлэлийн кластерийн тогтолцоогоор байгуулан ажиллуулж болно.

12.3.Дээд боловсролын сургалтын байгууллага Боловсролын тухай хуулийн 39.11-д зааснаас гадна сургалт-судалгааны зориулалт бүхий дараахь нэр төрлийн дэд санг сургууль хөгжүүлэх сангийн дотор байгуулж болно:

12.3.1.ажил олгогчдын захиалга, санхүүжилтээр оюутан сургах, сургалт судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих сан;

12.3.2.тэтгэлгийн сан;

12.3.3.эрсдэлийн сан;



- 12.3.4.хөрөнгө оруулалтын сан;
- 12.3.5.тусгай зориулалттай бусад сан.

12.4.Энэ хуулийн 12.3-т заасан санг бүрдүүлэх эх үүсвэр, сангийн зориулалт, зарцуулалт, гүйцэтгэлийг хянахтай холбогдсон журмыг удирдах зөвлөл батлах бөгөөд сангийн орлого, зарлагын тайлан нь тухайн сургалтын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.”

8/13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг:

“13.6.Багшийн хийж гүйцэтгэх сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил болон ажлын ачааллыг тооцох аргачлалыг сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн тогтоох бөгөөд багшийн ажлын ачааллыг тогтоохдоо түүний мэдлэг, ур чадвараа тогтмол дээшлүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, суралцагчтай үр бүтээлтэй ажиллах, захиргааны ажилд оролцох нөхцөл, бололцоог харгалзан үзнэ.”

9/14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт:

“14.1.4.дангаараа болон их сургууль, дээд сургууль, эрдэмтдийн баг, хуулийн этгээдтэй хамтран ажиллах болон гарааны компани байгуулах.”

10/16 дугаар зүйлийн 16.1.8 дахь заалт:

“16.1.8.их сургууль, дээд сургуулийн дэргэд байгуулагдсан гарааны компанид хичээлийн бус цагаар ажиллах, өөрөө гарааны компани байгуулах.”

2 дугаар зүйл.Дээд боловсролын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг:

“4.2.Их сургууль нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байх бөгөөд их сургууль нь магистр, докторын сургалт дагнан эрхэлж болно.”

2/4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг:

“4.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”

3/5 дугаар зүйлийн 5.2-5.4 дэх хэсэг:

“5.2.Их сургууль харьяалалдаа дээд сургууль, коллеж, технологийн коллеж, эрдэм шинжилгээний байгууллага, гарааны компани, ахлах сургуультай байж болно.

5.3.Дээд сургууль харьяалалдаа коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, эрдэм шинжилгээний хүрээлэн, ахлах сургуультай байж болно.

5.4.Коллеж нь харьяалалдаа политехник коллежтой байж болно.”

4/7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг:

“7.2.Элсэгчдийн тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох бусад стандартад нийцүүлэн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл тогтооно.”

5/8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэг:

“8.1.Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалтыг үндсэн болон цагаар гэсэн хэлбэрээр зохион байгуулна.

8.2.Их сургууль, дээд сургууль, коллежийн үндсэн сургалтын хичээлийн жилийн эхлэх хугацааг дээд боловсролын сургалтын тухайн байгууллага тогтоох бөгөөд хичээлийн жил нь улиралд хуваагдана.”

6/8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг:

“8.4.Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалтыг хөтөлбөрт үндэслэн зохион байгуулах бөгөөд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сургуулийн Эрдмийн зөвлөл хэлэлцэж, сургуулийн захирал батлах бөгөөд



сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”

7/11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг:

“11.1.Ашгийн төлөө бус төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг тухайн сургуулийн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.”

8/12 дугаар зүйлийн 12.1.9-12.1.11 дэх заалт:

“12.1.9.шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө боловсролын магадлан итгэмжлэх байгууллагад хандаж, урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэх;

12.1.10.үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, технологийн судалгаа хийх, шинжлэх ухааны парктay хамтарч ажиллах;

12.1.11.гадаадын болон дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах.”

9/13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:

“13.1.Их сургууль, дээд сургууль, коллежид мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бөгөөд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана. Инженер, технологийн чиглэлээр сургалт явуулдаг коллежид мэргэшсэн инженер зааж болно.”

10/16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг:

“16.2.Суралцагч Боловсролын тухай хуулийн 45.2-т зааснаас гадна сургуулийн дотоод дүрэм, журамд заасан үүргийг биелүүлнэ”.

3 дугаар зүйл.Дээд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “Төрийн бус өмчийн” гэснийг “Ашгийн төлөө бус” гэж, мөн хэсгийн “үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээд” гэснийг “удирдах зөвлөл” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын “төрийн

бодлогод” гэснийг “төрийн бодлого, дээд боловсролын хөгжлийн дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд” гэж, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсгийн дугаарыг “4.6” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Дээд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “дипломын болон” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Эрдмийн болон сургалт-арга зүйн зөвлөлийн дарга нь тухайн сургуулийн захирал байна.” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.1.7 дахь заалтын “, оюутан, магистрантын эрдэм шинжилгээний ажил удирдах” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Дээд боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.4, 13.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бага, дунд боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг:

“7.5.Гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ эзэмшүүлэх хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална.”

2/14 дүгээр зүйлийн 14.11 дэх хэсэг:



“14.11.Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”

3/20 дугаар зүйлийн 20.2.10-20.2.15 дахь заалт:

“20.2.10.сургалтын агуулга, багшийн арга зүйн чиглэлээр мэргэжлийн багшид зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

20.2.11.шийдвэр гаргахад багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл, багш, суралцагч, эцэг, эх, олон нийтийн оролцоог хангах, сургуулийн үйл ажиллагаа, сургалтын явц, үр дүнгийн талаар нээлттэй мэдээлэх;

20.2.12.сургууль, багшийн үйл ажиллагаа, сургалтын чанар, үр дүнд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг арга зүйн удирдамжаар хангах;

20.2.13.сургуулийн орчин дахь хоол, хүнс, ундны цэвэр ус, бие засах газрын эрүүл ахуй, аюулгүй байдлын баталгааг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

20.2.14.суралцагчийг сургуулийн ойр орчинд гэмт хэрэг, зөрчил зэрэг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хяналт тавих;

20.2.15.сургуулийн орчинд хүүхдийн эрхийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, хяналт тавих.”

4/22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг:

“22.3.Багш нь анги удирдаж, заах аргын нэгдэл хариуцан ажиллаж болно.”

2 дугаар зүйл.Бага, дунд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “хөтөлбөрийн” гэсний өмнө “цөм” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Бага, дунд боловсролын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйл:

“2 дугаар зүйл.Бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилго

2.1.Бага боловсролын зорилго нь эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх, суурь боловсролын зорилго нь амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх, бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэхэд тус тус оршино.”

2/14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг:

“14.5.Төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

3/20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт:

“20.2.2.сургууль хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад багш, сурагч, эцэг, эх, олон нийтийн оролцоо, түншлэлийг ханган ажиллах;”

4/20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалт:

“20.2.4.сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг сургуулийн зөвлөл, багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, мэдээлэх;”

4 дүгээр зүйл.Бага, дунд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийн “Төрөлжсөн, гүнзгийрүүлсэн,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ, СУРАЛЦАГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.4 дэх хэсэг нэмсүгэй:

“12.4. Дээд боловсролын сургалтын байгууллага санхүүгийн хувьд бие даасан байдлаа хадгалах талаар дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

12.4.1. судалгаа, шинжилгээ, зөвлөгөө өгөх үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүнийг зах зээлд худалдан борлуулах зорилгоор гарааны компани байгуулж ажиллуулах;

12.4.2. хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, сургалтын материаллаг орчныг сайжруулах зорилгоор үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгөө барьцаалан банкнаас зээл авах;

12.4.3. суралцагчид төрөл бүрийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

12.4.4. сургалт, судалгааны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор тодорхой төрлийн дэд сан байгуулах, сангийн хөрөнгөө арвижуулах талаар хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа эрхлэх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 04 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.14-4.1.16 дахь заалт:

“4.1.14. “халамжийн цэцэрлэг” гэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг;

4.1.15. “гэр цэцэрлэг” гэж алслагдсан сум, баг, хорооны цэцэрлэгт хамрагдаагүй хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх цэцэрлэгт түшиглэсэн асрах, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.16. “салбар бүлэг” гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг цэцэрлэгт түшиглэн эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтийн дагуу цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэрээр эрүүл, аюулгүй, хамгаалагдсан, стандартад нийцсэн сургалтын орчин бүхий хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагааг.”

2/7¹ дүгээр зүйл:

“7¹ дүгээр зүйл. Сургуулийн өмнөх боловсрол олгох хэлбэр

7¹.1. Сургуулийн өмнөх боловсролыг үндсэн болон хувилбарт сургалтаар олгоно.

7¹.2. Сургуулийн өмнөх боловсролд хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдийг хамруулна.”

3/8 дугаар зүйлийн 8.16 дахь хэсэг:



“8.16.Цэцэрлэгт бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлийн сургууль төгссөн хөгжмийн болон биеийн тамирын багш ажиллаж болно.”

4/14 дүгээр зүйлийн 14.2.7, 14.2.8 дахь заалт:

“14.2.7.хүүхдийн эрүүл, аюулгүй сурч, хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх талаар харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлж, цэцэрлэгийн эрхлэгчтэй гэрээ байгуулах;

14.2.8.хүүхдийнхээ хоолны зардлын тодорхой хувийг хариуцах.”

5/15 дугаар зүйлийн 15.3-15.5 дахь хэсэг:

“15.3.Уртасгасан цагийн бүлэг, зуны улиралд ажиллах салбар бүлгийн үйл ажиллагаанд шаардагдах нийт зардлыг хүсэлт гаргагч эцэг, эх, асран хамгаалагч хариуцна.

15.4.Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг эцэг, эх, асран хамгаалагчаас, Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2-т заасан хүүхдийн хоолны зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

15.5.Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.”

2 дугаар зүйл.Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “асрамжийн” гэсний дараа “, халамжийн” гэж, мөн зүйлийн 8.6 дахь хэсгийн “Тусгай” гэсний дараа “, гэр цэцэрлэг” гэж, мөн хэсгийн “асрамжийн” гэсний дараа “болон халамжийн” гэж, мөн зүйлийн 8.9 дэх хэсгийн “ажиллана.” гэсний дараа “Бүлэгт хүүхдийн тооноос хамаарч ээлжийн багш ажиллаж болно.” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Багшид” гэсний дараа “Боловсролын тухай хуулийн 28.1.22-т заасан журмын дагуу” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “гомдол гаргах” гэсний дараа “, хяналт тавих” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

“3.1.Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт:

“4.1.1.“хүүхдийн цэцэрлэг” гэж /цаашид “цэцэрлэг” гэх/ хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг;”

3/4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт:

“4.1.8.“үндсэн сургалт” гэж цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмших сургалт болон хөгжүүлэх үйл ажиллагааны цогцыг;”

4/4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт:

“4.1.13.“туслах багш” гэж хүүхэд бүрд сургуулийн өмнөх боловсрол олгох, асрах, хамгаалах, хөгжүүлэх үйл ажиллагаанд хамтран оролцдог, багшид туслах үүрэгтэй, мэргэжлийн сургалтад хамрагдсан ажилтныг.”

5/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:

“7.1.Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

6/9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг:

“9.7.Цэцэрлэг нь эцэг, эх, асран хамгаалагчийн санал, хүсэлтэд үндэслэн Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.7, 8.8, 8.9, 8.10-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд хоёр хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж болно.”

7/16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2 дахь заалт:

“16.2.1.энэ хуулийн 11.2.9, 11.2.10-т заасныг зөрчсөний улмаас хүүхэд, багш, ажилтны эрүүл мэндэд хохирол учирсан бол буруутай албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

16.2.2.энэ хуулийн 14.2.2, 14.2.3-т заасан үүргээ биелүүлээгүй эцэг, эх, асран хамгаалагчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.”

4 дүгээр зүйл.Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “дипломын” гэснийг “бакалавр” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хоолны зардал,” гэснийг “хоолны зардлын тодорхой хувь,” гэж тус тус өөрчилсүгэй.



5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 05 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн
тойрог байгуулах, тойргийн мандатын
тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг
тогтоох тухай**

Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 76 тойрог байгуулсугай.

2.Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Өргөн сумдыг Говьсүмбэр аймагтай; Нийслэлийн Багахангай дүүргийг Хан-Уул дүүргийн 11, 13, 15 дугаар хороотой; Налайх дүүргийг Чингэлтэй дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хороотой; Багануур дүүргийн 1 дүгээр хороог Сүхбаатар дүүргийн 7, 8, 9, 10 дугаар хороотой; Багануур дүүргийн 2 ба 4 дүгээр хороог Сүхбаатар дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хороотой; Багануур дүүргийн 3 дугаар хороог Сүхбаатар дүүргийн 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороотой; Багануур дүүргийн 5 дугаар хороог Сүхбаатар дүүргийн 11, 12, 13, 14 дүгээр хороотой тус тус нэгтгэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн нэг тойрог болгосугай.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог, тойргийн нутаг дэвсгэр, дугаар, төв, мандатын тоог хавсралтаар баталсугай.

4.Энэ тогтоолыг 2016 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2016 оны
 41 дүгээр тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТӨЙРОГ, ТӨЙРГИЙН НУТАГ ДЭВСГЭР,
 ДУГААР, ТӨВ, МАНДАТЫН ТОО**

| Тойргийн дугаар | Аймаг, дүүрэг | Тойргийн нутаг дэвсгэр | Тойргийн төв | Мандатын тоо |
|-----------------|------------------|--|------------------------|--------------|
| 1 | | Архангай аймгийн Булган, Ихтамир, Өндөр-Улаан, Тариат, Хангай, Цахир, Чулуут, Жаргалант сум | Эрдэнэбулган сумын төв | 1 |
| 2 | Архангай аймаг | Мөн аймгийн Эрдэнэбулган сумын 1, 2, 3, 4, 5, 6, 7 дугаар баг, Төвшрүүлэх, Цэнхэр сум | Эрдэнэбулган сумын төв | 1 |
| 3 | | Мөн аймгийн Өгийнуур, Өлзийт, Хашаат, Хотонт, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Хайрхан, Батцэнгэл сум | Эрдэнэбулган сумын төв | 1 |
| 4 | | Баян-Өлгий аймгийн Сагсай, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Бугат сум, Өлгий сумын 7 дугаар баг /Хотгор/ | Өлгий сумын төв | 1 |
| 5 | Баян-Өлгий аймаг | Мөн аймгийн Өлгий сумын 1, 2, 3, 4, 5, 6, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар баг | Өлгий сумын төв | 1 |
| 6 | | Мөн аймгийн Алтай, Буянт, Толбо, Булган, Дэлүүн, Алтанцөгц, Баяннуур сум | Өлгий сумын төв | 1 |
| 7 | | Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1 дүгээр баг /Номгон/, 4 дүгээр баг /Угалз/, 8 дугаар баг /Шаргалжуут/, Өлзийт, Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст сум | Баянхонгор сумын төв | 1 |
| 8 | Баянхонгор аймаг | Мөн аймгийн Баацаган, Баян-Өндөр, Баянцагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянбулаг сум, Баянхонгор сумын 2 дугаар баг /Эрдэнэмандал/, 7 дугаар баг /Цахир/, 9 дүгээр баг /Есөнбулаг/ | Баянхонгор сумын төв | 1 |
| 9 | | Мөн аймгийн Галуут, Гурванбулаг, Заг, Жаргалант, Эрдэнэцогт, Баян-Овоо сум, Баянхонгор сумын 3 дугаар баг /Дуурсах/, 5 дугаар баг /Цагаанчулуут/, 6 дугаар баг /Гэгээншавь/ | Баянхонгор сумын төв | 1 |



| | | | | |
|----|-----------------------------------|--|----------------------|---|
| 10 | Булган аймаг | Булган аймгийн Булган, Баян-Агт, Бугат, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хугаг-Өндөр, Баяннуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Хишиг-Өндөр сум | Булган сумын төв | 1 |
| 11 | Говь-Алтай аймаг | Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Алтай, Баян-Уул, Бугат, Дарив, Жаргалан, Шарга, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Бигэр, Дэлгэр, Тайшир, Халиун, Цогт, Цээл, Чандмань, Эрдэнэ сум | Есөнбулаг сумын төв | 1 |
| 12 | Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг | Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Шивээговь, Баянтал сум, Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Иххэт, Сайхандулаан, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Өргөн сум | Сайншанд сумын төв | 1 |
| 13 | Дорноговь аймаг | Дорноговь аймгийн Замын-Үүд, Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Сайншанд сум | Сайншанд сумын төв | 1 |
| 14 | Дорнод аймаг | Дорнод аймгийн Хэрлэн сумын 1, 6, 8, 9, 10 дугаар баг, Гурванзагал, Сэргэлэн, Чойбалсан, Булган, Магад, Халхгол, Хөленбуур сум | Хэрлэн сумын төв | 1 |
| 15 | | Мөн аймгийн Хэрлэн сумын 2, 3, 4, 5, 7 дугаар баг, Баяндун, Баянтүмэн, Дашбалбар, Чулуунхороот, Баян-Уул, Цагаан-Овоо сум | Хэрлэн сумын төв | 1 |
| 16 | Дундговь аймаг | Дундговь аймгийн Адаацаг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Луус, Сайнцагаан, Сайхан-Овоо, Хулд, Цагаандэлгэр, Эрдэнэдалай, Өлзийт, Өндөршил сум | Сайнцагаан сумын төв | 1 |

| | | | | |
|----|------------------|--|-----------------------|---|
| 17 | Завхан аймаг | Завхан аймгийн Асгат, Баянтэс, Баянхайрхан, Идэр, Их-Уул, Нөмрөг, Сонгино, Тосонцэнгэл, Тэлмэн, Тэс, Түдэвтэй, Цэцэн-Уул, Яруу сум | Улиастай сумын төв | 1 |
| 18 | | Мөн аймгийн Алдархаан, Отгон, Шилүүстэй, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Дөрвөлжин, Ургамал, Завханмандал, Сантмаргац, Эрдэнэхайрхан сум, Улиастай сумын 1, 2, 3, 4, 5, 6 дугаар баг | Улиастай сумын төв | 1 |
| 19 | Өвөрхангай аймаг | Өвөрхангай аймгийн Хужирт, Зүүнбаян-Улаан, Уянга, Бат-Өлзий, Хархорин сум | Арвайхээр сумын төв | 1 |
| 20 | | Мөн аймгийн Арвайхээр, Тарагт сум | Арвайхээр сумын төв | 1 |
| 21 | Өмнөговь аймаг | Мөн аймгийн Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Баян-Өндөр, Сант, Баянгол, Төгрөг, Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан сум | Арвайхээр сумын төв | 1 |
| 22 | | Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 1 дүгээр баг /Баруунсайхан/, 2 дугаар баг /Хан-Уул/, 5 дугаар баг /Зүүнсайхан/, 7 дугаар баг /Юуут/, 8 дугаар баг /Цагаанбулаг/, Хүрмэн, Баяндалай, Ноён, Сэврэй, Гурвантэс, Булган, Мандал-Овоо, Ханхонгор сум | Даланзадгад сумын төв | 1 |
| 23 | Сүхбаатар аймаг | Мөн аймгийн Даланзадгад сумын 3 дугаар баг /Төв/, 4 дүгээр баг /Дундсайхан/, 6 дугаар баг /Их-Уул/, Цогт-Овоо, Цогтцэдий, Манлай, Ханбогд, Баян-Овоо, Номгон сум | Даланзадгад сумын төв | 1 |
| 24 | | Сүхбаатар аймгийн Баруун-Урт, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Асгат, Халзан, Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Наран, Онгон, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сум | Баруун-Урт сумын төв | 1 |

| | | | | |
|----|-----------------------------|--|---------------------|---|
| 25 | Сэлэнгэ аймгийн Шлаамар сум | Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Жавхлانت, Сүхбаатар, Хүдэр, Сүхбаатар сум | Сүхбаатар сумын төв | 1 |
| 26 | Сэлэнгэ аймаг | Мөн аймгийн Баянгол, Ерөө, Мандал сум | Сүхбаатар сумын төв | 1 |
| 27 | | Мөн аймгийн Баруунбүрэн, Зүүнбүрэн, Орхон, Орхонтуул, Сайхан, Сант, Тушиг, Хушаат, Цагааннуур сум | Сүхбаатар сумын төв | 1 |
| 28 | | Төв аймгийн Арухст, Баян, Баяндэлгэр, Баянжаргалан, Баянцагаан, Мөнгөнморьт, Эрдэнэ, Батсүмбэр, Сэргэлэн сум, Зуунмод сумын 2 дугаар баг /Ланс/, 6 дугаар баг /Баруун зуунмод/ | Зуунмод сумын төв | 1 |
| 29 | Төв аймаг | Мөн аймгийн Аргалант, Алтанбулаг, Баянхангай, Баянцогт, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Лүн, Өндөрширээт, Эрдэнэсант сум, Зуунмод сумын 3 дугаар баг /Баянхошуу/, 5 дугаар баг /Нацагдорж/ | Зуунмод сумын төв | 1 |
| 30 | | Мөн аймгийн Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Сүмбэр, Угтаалцайдам, Цээл сум, Зуунмод сумын 1 дүгээр баг /Номт/, 4 дүгээр баг /Зүүндэлгэр/ | Зуунмод сумын төв | 1 |
| 31 | | Увс аймгийн Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Цагаанхайрхан, Давст, Сагил сум, Улаангом сумын 3, 7, 8, 12 дугаар баг | Улаангом сумын төв | 1 |
| 32 | Увс аймаг | Мөн аймгийн Малчин, Хяргас, Завхан, Наранбулаг, Тариалан, Ховд сум, Улаангом сумын 4, 9, 10, 11 дүгээр баг | Улаангом сумын төв | 1 |
| 33 | | Мөн аймгийн Өндөрхангай, Зүүнхангай, Өлгий, Өмнөговь, Бөхмөрөн, Түргэн сум, Улаангом сумын 1, 2, 5, 6 дугаар баг | Улаангом сумын төв | 1 |
| 34 | | Ховд аймгийн Дарви, Дөргөн, Зэрэг, Цэцэг, Чандмань сум, Жаргалант сумын Бугат, Жаргалан, Рашаант, Хайрхан баг | Жаргалант сумын төв | 1 |
| 35 | Ховд аймаг | Мөн аймгийн Алтай, Буянт, Манхан, Мөст, Үенч сум, Жаргалант сумын Баатархайрхан, Бичигт, Наран, Тахилт баг | Жаргалант сумын төв | 1 |
| 36 | | Мөн аймгийн Булган, Дуут, Мөнххайрхан, Мянгад, Ховд, Эрдэнэбүрэн сум, Жаргалант сумын Алагтолгой, Буянт, Магсаржав, Цамбагарав баг | Жаргалант сумын төв | 1 |

| | | | | |
|----|------------------|--|---|---|
| 37 | Хөвсгөл аймаг | Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10, 11, 12, 13, 14 дүгээр баг, Баянзүрх, Улаан-Уул, Цагаануур, Ренчинлхүмбэ, Алаг-Эрдэнэ, Ханх, Чандмань-Өндөр сум | Мөрөн сумын төв | 1 |
| 38 | | Мөн аймгийн Мөрөн сумын 5, 7, 8, 9 дүгээр баг, Арбулаг, Цэцэрлэг, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Түнэл, Эрдэнэбулган, Цагаан-Үр, Тариалан сум | Мөрөн сумын төв | 1 |
| 39 | | Мөн аймгийн Мөрөн сумын 1, 2, 3, 4, 6 дугаар баг, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Рашаант, Их-Уул сум | Мөрөн сумын төв | 1 |
| 40 | Хэнтий аймаг | Хэнтий аймгийн Батширээт, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Өмнөдэлгэр, Цэнхэрмандал, Бор-Өндөр сум | Хэрлэн сумын төв | 1 |
| 41 | | Мөн аймгийн Батноров, Баян-Адрага, Баян-Овоо, Баянхутаг, Галшар, Дадал, Норовлин, Биндэр сум | Хэрлэн сумын төв | 1 |
| 42 | | Мөн аймгийн Жаргалтхаан, Мөрөн, Хэрлэн сум | Хэрлэн сумын төв | 1 |
| 43 | | Дархан-Уул аймгийн Дархан сумын 4, 5, 6, 7, 8, 9 дүгээр баг, 17 дугаар баг /Өргөө/ | Дархан сумын төв | 1 |
| 44 | | Мөн аймгийн Дархан сумын 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар баг | Дархан сумын төв | 1 |
| 45 | Дархан-Уул аймаг | Мөн аймгийн Дархан сумын 1, 2, 3, 18 дугаар баг /Малчин/, Орхон, Хонгор, Шарын гол сум | Дархан сумын төв | 1 |
| 46 | | Орхон аймгийн Баян-Өндөр сумын Хүрэнбулаг, Зэст, Баянцагаан, Говил, Яргуйт, Эрдэнэ баг, Жаргалант сум | Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар | 1 |
| 47 | Орхон аймаг | Мөн аймгийн Баян-Өндөр сумын Уурхайчин, Оюут, Согоот, Дэнж, Уртын гол, Их залуу, Шанд баг | Мөн Тамгын газар | 1 |
| 48 | | Мөн аймгийн Баян-Өндөр сумын Уртбулаг, Бүрэнбуст, Цагаанчулуут, Баянбулаг, Булаг, Наран, Даваат, Рашаант баг | Мөн Тамгын газар | 1 |

| | | | | | |
|----|------------------|--|---|--|---|
| 49 | | | Нийслэлийн Баянзүрх дүүргийн 1, 2, 3, 7, 21, 27 дугаар хороо | Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар | 1 |
| 50 | | | Мөн дүүргийн 6, 15, 18, 25, 26 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 51 | Баянзүрх дүүрэг | | Мөн дүүргийн 4, 5, 14 дүгээр хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 52 | | | Мөн дүүргийн 9, 17, 19, 22, 24 дүгээр хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 53 | | | Мөн дүүргийн 11, 12, 13, 16 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 54 | | | Мөн дүүргийн 8, 10, 20, 23, 28 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 55 | | | Хан-Уул дүүргийн 1, 2, 3, 12 дугаар хороо | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар | 1 |
| 56 | Хан-Уул дүүрэг | | Мөн дүүргийн 11, 13, 15 дугаар хороо, Багахангай дүүрэг | Мөн Тамгын газар | 1 |
| 57 | | | Мөн дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 58 | | | Мөн дүүргийн 9, 10, 14, 16 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 59 | Сүхбаатар дүүрэг | | Сүхбаатар дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хороо, Багануур дүүргийн 2 ба 4 дүгээр хороо | Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар | 1 |
| 60 | | | Мөн дүүргийн 7, 8, 9, 10 дугаар хороо, Багануур дүүргийн 1 дүгээр хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 61 | | | Мөн дүүргийн 11, 12, 13, 14 дүгээр хороо, Багануур дүүргийн 5 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 62 | | | Мөн дүүргийн 15, 16, 17, 18, 19, 20 дугаар хороо, Багануур дүүргийн 3 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |

| | | | | |
|------------|-----------------------|---|---|-----------|
| 63 | Чингэлтэй дүүрэг | Чингэлтэй дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6 дугаар хороо, Налайх дүүрэг | Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар | 1 |
| 64 | Чингэлтэй дүүрэг | Мөн дүүргийн 7, 8, 9, 10, 11 дүгээр хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 65 | | Мөн дүүргийн 12, 13, 14, 15 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 66 | | Мөн дүүргийн 16, 17, 18, 19 дүгээр хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 67 | Баянгол дүүрэг | Баянгол дүүргийн 1, 2, 3, 4, 20 дугаар хороо | Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар | 1 |
| 68 | | Мөн дүүргийн 5, 6, 7, 9, 21 дүгээр хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 69 | | Мөн дүүргийн 8, 10, 12, 13, 14, 22 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 70 | | Мөн дүүргийн 11, 15, 16, 17, 18, 19, 23 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 71 | Сонгинохайрхан дүүрэг | Сонгинохайрхан дүүргийн 12, 13, 14, 15, 16, 17, 30, 31 дүгээр хороо | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар | 1 |
| 72 | | Мөн дүүргийн 18, 19, 23, 27, 29 дүгээр хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 73 | Сонгинохайрхан дүүрэг | Мөн дүүргийн 8, 10, 11, 21, 28 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 74 | | Мөн дүүргийн 7, 9, 24, 25 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 75 | | Мөн дүүргийн 1, 2, 20, 22, 32 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| 76 | | Мөн дүүргийн 3, 4, 5, 6, 26 дугаар хороо | Мөн Тамгын газар | 1 |
| ДҮН | | | | 76 |



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 3 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 153

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 10.1, Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Болор, Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар батлах тухай” Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 134 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

САНГИЙН САЙД

Б.БОЛОР

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЙД

Д.ЭРДЭНЭБАТ

Засгийн газрын 2016 оны 153 дугаар
тогтоолын хавсралт

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Сум хөгжүүлэх сан (цаашид “сан” гэх)-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлөлттэй зээл олгоход зориулан зарцуулна.



1.3. Сангийн орлого, зарлагыг Төрийн сан дахь тусгай дансаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд сан Төрийн сангаас гадуур данстай байхыг хориглоно.

1.4. Энэ журмын 1.3-т заасан дансанд сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно.

1.5. Сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг тухайн сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, улирал, жилийн тайланд тусгана.

1.6. Сангаас иргэн, хуулийн этгээдэд олгох хөнгөлөлттэй зээл дараах нөхцөлтэй байна:

1.6.1. зээлийн хүүгийн хэмжээ нь жилд 3 хувь байна (энэ нь өмнөх жилүүдэд байгуулсан зээлийн гэрээнд заасан хүүгийн хэмжээг өөрчлөх үндэслэл болохгүй);

1.6.2. зээлийн хугацаа нь 36 хүртэл сар байна.

1.7. Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана.

1.8. Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна.

1.9. Сангийн хөрөнгийг энэ журмын 1.5, 1.8-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

1.10. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалттай холбогдуулан иргэн, хуулийн этгээдээс аливаа хэлбэрээр шимтгэл, хураамж, төлбөр авахыг хориглоно.

1.11. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

Хоёр. Сангийн хөрөнгийн эх үүсвэр

2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

2.1.1. улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө;



2.1.2. гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж;

2.1.3. сангаас олгосон зээлийн хүүгийн орлого;

2.1.4. хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги.

2.2. Аймаг, сумын төсвийн хөрөнгө болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хэсгийн хөрөнгөөс санд хандив өгөхийг хориглоно.

2.3. Санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжсөн байдал, хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, зээлийн эргэн төлөлт, ашиглалт, хэрэгцээ, шаардлага, орон нутгийн идэвх, санаачилга зэргийг харгалзан төсвийн болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

Гурав. Сангийн удирдлага, зохион байгуулалт

3.1. Сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэх бөгөөд төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхтэй:

3.1.1. жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх талаар Засгийн газраас баримталж байгаа бодлого, сангийн хөрөнгө оруулалтын бодлогын уялдаа, холбоо хангаж ажиллах;

3.1.2. жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулах төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги” болон “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-тэй уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

3.1.3. сангаас олгох зээлийн болон барьцааны гэрээний загвар, тайлан, мэдээ гаргах маягыг батлах;

3.1.4. сангаас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд оруулах;

3.1.5. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.2. Сангийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүргийг тухайн аймгийн Засаг дарга (Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгж) хэрэгжүүлэх бөгөөд Засаг дарга нь дараах бүрэн эрхтэй:

3.2.1. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги” болон “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-тэй уялдуулан харьяалах нутаг дэвсгэртээ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих;

3.2.2. аймгийн хэмжээнд сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэрлэх;

3.2.3. аймгийн хэмжээнд сангаас олгосон зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, тайлан, мэдээг хянан баталгаажуулах, тэдгээрийг жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэх;

3.2.4. харьяалах нутаг дэвсгэртээ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах;

3.2.5. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.3. Сангийн үйл ажиллагааны талаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох;

3.3.2. сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчээр ахлуулан, Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;

3.3.3. сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг тухайн сумын Засаг даргаар ахлуулан, Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо, банк болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулах;



3.3.4. сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн зохих журмын дагуу шийдвэрлэх;

3.3.5. хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

3.4. Энэ журмын 3.3.2, 3.3.3-т заасан зөвлөлийн гишүүн ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах үүрэгтэй бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

3.4.1. зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах багийн төлөөллийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэн сонгосон байх;

3.4.2. тухайн нэг зөвлөлийн гишүүнийг нөгөө зөвлөлийн гишүүнээр давхар ажиллуулахгүй байх;

3.4.3. хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

3.5. Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.5.1. төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаанд сумын иргэдийн оролцоог хангах ажлыг зохион байгуулах;

3.5.2. энэ журамд заасны дагуу зээл олгох шийдвэр гаргах;

3.5.3. энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах;

3.5.4. энэ журмын 3.5.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаанд бариулах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх;

3.5.5. зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх;

3.5.6. сангийн орлого, зарлагыг хөтлөх үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийг мөрдүүлж, сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах;



3.5.7. сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

3.5.8. сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах;

3.5.9. сумын иргэн, хуулийн этгээдэд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх болон бусад шаардлагатай асуудлаар мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх саналаа аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх, иргэдийн дунд сургалт зохион байгуулж, оролцоог хангаж ажиллах.

Дөрөв. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал хүлээн авах, сонгон шалгаруулах журам

4.1. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн талаарх саналаа тогтоосон хугацаанд энэ журмын 3.3.3-т заасан зөвлөлд хүргүүлнэ.

4.2. Сангаас зээл авч, төсөл хэрэгжүүлэх жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэн, хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

4.2.1. тухайн суманд бүртгэлтэй буюу байнга оршин сууж үйл ажиллагаа явуулдаг байх;

4.2.2. сум хөгжүүлэх болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх;

4.2.3. зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх;

4.2.4. жижиг, дунд үйлдвэр эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх (түүнийг нь нотлох баримт бичиг шаардлагатай).

4.3. Энэ журмын 4.2-т заасан иргэн, хуулийн этгээдийн боловсруулсан төсөл дараах шалгуурыг хангасан байна:

4.3.1. тухайн суманд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх;

4.3.2. төслийн хүрэх үр дүн, зорилт тодорхой байх;



4.3.3. гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх;

4.3.4. төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх;

4.3.5. төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, даван туулах арга замыг тусгасан байх;

4.3.6. ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх.

4.4. Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөл иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн төсөл мөн журмын 4.3-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянах бөгөөд зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар зохих шийдвэрийг гаргана. Зөвлөл тухайн төслийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан тохиолдолд саналаа ажлын 3 хоногийн дотор тухайн сумын Засаг даргад хүргүүлнэ. Зөвлөлийн хуралд нийт гишүүдийн гуравны хоёр оролцсон тохиолдолд хурлын ирц бүрдсэн гэж үзнэ.

4.5. Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор тухайн сумын Засаг дарга зээл олгох шийдвэр гаргана.

4.6. Сумын Засаг дарга төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулна. Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн дансанд шилжүүлнэ.

4.7. Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө.

4.8. Сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална:

4.8.1. зээлдэгчийн анкет;

4.8.2. зээл олгохыг хүссэн өргөдөл;

4.8.3. оршин суугаа газрын тодорхойлолт;

4.8.4. төслийн баримт бичиг;

4.8.5. энэ журмын 3.3.3-т заасан зөвлөлийн хурлын тэмдэглэл;



4.8.6. зээлийн болон барьцааны гэрээ;

4.8.7. барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээг эх хувиар хавсаргах;

4.8.8. зээлийн эргэн төлөлтийн хуваарь;

4.8.9. энэ журмын 4.2, 4.3-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг баталгаажуулсан баримт бичиг.

4.9. Сумын Засаг дарга энэ журмын 4.9-д зааснаас гадна төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх бусад мэдээллийг тухай бүр баримтжуулан хадгална.

Тав. Сангийн үйл ажиллагааг тайлагнах,
хяналт тавих

5.1. Сангийн үйл ажиллагаа нийтэд ил тод, нээлттэй байна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад тухайн сумын иргэд хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж болно.

5.2. Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана.

5.3. Энэ журмын 3.3.2-т заасан зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1. зээл авсан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, санхүүгийн буюу мөнгөн гүйлгээ, зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргуулан авах;

5.3.2. сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;

5.3.3. аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгжийн хамт жилд нэгээс доошгүй удаа сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр хүргүүлэх.



5.4. Сумдын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн аймгийн Засаг даргад хүргүүлнэ.

5.5. Аймгийн Засаг дарга энэ журмын 5.4-т заасан сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн улирлын болон жилийн тайланг нэгтгэн, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.6. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 5.5-д заасан тайланг нэгтгэн, мөн журмын 5.8-д заасан аудитын дүгнэлтийн хамт тухайн жилийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

5.7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгж сангийн үйл ажиллагаа, орлого, зарлагын гүйцэтгэлд жил бүр хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг тухайн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

5.8. Аймгийн Засаг даргын Тамгын газрын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан нэгж энэ журмын 5.7-д заасан аудитын дүгнэлтийг аймгийн хэмжээнд нэгтгэн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. Сангаас зээл авсан этгээд зээлийг үр ашиггүй зарцуулсан буюу зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн болон барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн этгээдэд сангаас дахин зээл олгохгүй.

6.2. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй буюу энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулсан, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд хариуцан барагдуулна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2016 оны 05 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

**Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж;
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн
4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалт Үндсэн хуулийн
холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн П.Очирбат даргалж, гишүүдэд Ш.Цогтоо, Д.Сугар, Д.Наранчимэг /илтгэгч/, Д.Солонго нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Ц.Долгормааг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн С.Номынбаясгалан оролцож, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар хүн дэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж дэх заалтад “Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.”; Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалтад “Санхүүгийн зохицуулах хорооноос “холбогдох этгээд” гэж тодорхойлсон бусад этгээд.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэх заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандаж ирүүлсэн мэдээлэлдээ:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл нь нэг нийлмэл өгүүлбэр буюу хоёр энгийн өгүүлбэрээс бүрдэж, эдгээрийг “бөгөөд” гэх холбоосоор холбожээ. Эхний утга санаа болох “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага” гэдгийг тодорхойлон баталсан хэм



хэмжээ бол хоёр дахь утга санаа болох “хууль тогтоох эрх мэдэл Улсын Их Хуралд хадгалагдаж”, өөрийн онцгой бүрэн эрхэд хамаарах хууль батлах, нэмэлт оруулах асуудлыг гагцхүү чуулганаар хэрэгжүүлдэг тул “Шилжүүлж үл болох эрх” гэж үздэг. Үндсэн хуулийн бичвэрт, Улсын Их Хурлын “Бүрэн эрх”, “Онцгой бүрэн эрх” гэх утга санааг бий болгож, Улсын Их Хурал шаардлагатай тохиолдолд зөвхөн өөрийн бүрэн эрхэд л хамаарах асуудлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлж болохоос биш, онцгой бүрэн эрхээ шилжүүлэх талаар тусгагдаагүй. Эндээс, “Хууль бүтээх эрх”, “Хууль тогтоох эрх”, “Хууль тогтоох бүрэн эрх”, “Хууль хэвлэх эрх” гэх ойлголтуудыг бий болгох юм. Тийм ч учраас, Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх” утга санааг баталгаажуулж, хууль хэвлэх эрх бусад хуулиар хэрэгждэг. Тэгвэл хууль тогтоогч хуульд нэр томъёоны тодорхойлолтыг хэрхэн хийж буйгаас хамааран “Хуульчилсан тайлбар” буюу “Тайлбар” гэх хэлбэрт хувааж болох бөгөөд тэрхүү хуульчилсан тайлбар нь хууль болохынхоо хувьд, (1) Үндсэн тогтолцооныхоо суурь зарчимд захирагдмал, “(2) Хуульд хараат, (3) Тайлбарын хамрах хүрээ хуулийн зорилготой давхцсан,” байх ёстой. Гэтэл 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд /4.1.30.е/, 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан Банкны тухай хуульд /3.1.2.ж/ агуулга төсөөтэй “Санхүүгийн зохицуулах хорооноос, эсхүл Монгол банк “холбогдох этгээд” гэж тодорхойлсон, эсхүл үзсэн бусад этгээд” гэх заалт хүчин төгөлдөр үйлчилж, Үндсэн хуульд тусгагдаагүй үзэл санаа буюу хууль тогтоох эрх мэдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкинд шилжүүлэн “Үндсэн хуулийн зөрчил”-ийг үүсгэжээ. Учир нь хууль тогтоогч Банкны тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар “Холбогдох этгээд” гэдэгт хэнийг багтаах вэ? гэдгийг жагсааж өгсөн ч тэрхүү жагсаалтад “Нэмэлт хийх” эрхийг Монголбанкинд олгож, харин Санхүүгийн зохицуулах хороонд “Холбогдох этгээд”-ийг өөрийн үзэмжээр тодорхойлох субъектив эрх бий болгожээ. Өөрөөр хэлбэл, хуулиар тогтоосон хүрээ, хязгаарын дотор, ямар шалгуур, шалтгааныг үндэслэж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн “холбогдох этгээд”-ийн жагсаалтыг өргөтгөх эсэхийг субъект тус бүрээр нэг бүрчлэн тогтоох уу? гэдгийг хуульчлан тогтоогүй байж, жагсаалтад нэмэлт хийж өргөтгөх эрхийг шууд шилжүүлж байгаа нь хууль тогтоох эрх мэдэлд халдаж байна. Энэ нь хуулийн зорилго Үндсэн хуулийн зорилгод харшилж буйг харуулав.

Б. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг /1992-2015/ судлахад, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд /5 удаа/, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад /6 удаа/ холбогдох

дүгнэлт, тогтоол тус тус байна. Эдгээр шийдвэрт “Хууль тогтоох эрхийг бусдад шилжүүлэх нь үндсэн хуулийн зөрчил” гэсэн зарчмын шинжтэй нэгдмэл байр суурь тогтоожээ. Мөн энэ мэдээллийн агуулгатай төсөөтэй буюу Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т хамаарах Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар дүгнэлт байх бөгөөд энэхүү шийдвэрийн үндэслэх, дүгнэх хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэх буюу “Хууль тогтоох эрх мэдэл”-д халдсан, шилжүүлсэн эсэх талаар шийдвэр гаргаагүй байна. Тиймээс энэ мэдээллийн агуулга өөр тул урьд гаргасан Цэцийн дүгнэлт хүчинтэй гэх үндэслэлээр “Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзах”, “Мэдээлэл буцаах” боломжгүй юм.

Иймд Монгол Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж дэх заалтад “Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд” гэж, Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр баталсан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалтад “Санхүүгийн зохицуулах хорооноос “холбогдох этгээд” гэж тодорхойлсон бусад этгээд” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “Хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байх тул хянан хэлэлцэж дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын даргын 2016 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 39 дүгээр захирамжаар итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Б.Гарамгайбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“1. Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, үзэл санааны дагуу Банкны тухай болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг батлан гаргасан болно. Нийгмийн харилцаа улам бүр өргөжин, хурдтай өөрчлөгдөж байгааг түргэн оновчтой мэдэрч, улс орны эдийн засаг, банк, санхүү, бизнесийн салбарын аливаа асуудлыг уян хатан, шуурхай шийдвэрлэхийн тулд Улсын Их Хурлаас Засгийн газар, бусад этгээдэд тодорхой асуудлаар, тодорхой хязгаарын хүрээнд зөвхөн хуулиар эрх олгодог. Харин Үндсэн хууль, төрийн гадаад, дотоод бодлогын үндсийг тодорхойлсон хэм хэмжээ, хүний эрх чөлөө, сонгууль, мөнгөний бодлого, олон улсын гэрээ зэрэг асуудлаар уг эрхийг олгодоггүй.



Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд “бусад холбогдох этгээд”-ийг тодорхойлох эрхийг хуулиар олгосон нь Улсын Их Хурлаас байгуулагддаг, ажлаа шууд Улсын Их Хуралд шууд хариуцан тайлагнадаг, Монгол Улсын банк, санхүү, үнэт цаасны зах зээл, эдгээр салбарын үйл ажиллагаанд төрийн болон мэргэжлийн хяналт тавих, төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллагуудынх нь хувьд тэдэнд “бусад холбогдох этгээд”-ийг тодорхойлохыг зөвшөөрөх хүрээнд зохицуулагдсан асуудал юм.

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцдаг. Энэ үүргийг биелүүлэхэд төрийн байгууллага бүр тодорхой чиг үүрэгтэйгээр байгуулагддаг бөгөөд гаргаж байгаа эрх зүйн акт нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх ёстой. Хэрэв Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага эрх мэдлээ хэтрүүлсэн, хууль зөрчсөн, Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан шийдвэр гаргавал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.11 дэх заалтын дагуу Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо уг эрх зүйн актыг хянаж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авах эрхтэй.

2. “Холбогдох этгээд” гэсэн нэр томъёог Банкны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиас гадна хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд мөн хэрэглэсэн байдаг. Компанийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд “нэгдмэл сонирхолтой этгээд” гэсэн нэр томъёог “холбогдох этгээд”-тэй адил зорилгоор оруулж тодорхойлжээ.

Банк, санхүү, үнэт цаасны зах зээл нь төрөөс мэргэжлийн онцгой хяналт, зохицуулалт шаарддаг учраас банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, эрсдэлээс байнга урьдчилан сэргийлэх зорилгоор уг ойлголтыг байж болох бүхий л хүрээг хамарч тодорхойлох нь холбогдох этгээдийн гинжин холбоог тогтоох, банк, санхүүгийн зах зээлд томоохон хувьцаа эзэмшигч, удирдлагуудын ашиг сонирхлыг хязгаарлах, сонирхлын зөрчлийг зохицуулах, холбогдох этгээдийн хооронд үнэт цаасны арилжааны үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх зэргийг хязгаарлах, улмаар эрх зүйн зохицуулалтын аливаа хийдэл гаргахгүй байх боломжийг олгож байгаа болно.



Холбогдох этгээд гэдэгт ямар субъектийг тооцох, шинж, агуулгын хувьд хэн байх зэргийг Үнэт цаасны зах зээлийн тухай, Банкны тухай хуульд зааснаас гадна хяналт шалгалтын зорилгоор зохицуулагч байгууллага тодорхойлох эрхтэй байхаар хуульчилсан нь уг зах зээлийн хурдтай өөрчлөлт, онцлогийг харгалзан үзсэн явдал бөгөөд түүнд оролцогч талуудыг зөв тогтоосноор тэдгээрийн харилцан хамаарлыг гаргах чухал ач холбогдолтой байдаг. Үүнийг хуулиар бүрэн зохицуулах бололцоо бага байдаг тул санхүүгийн зах зээлийг зохицуулж буй зохицуулагч байгууллага өөрийн дүрэм, журмаар зохицуулах шаардлага гардаг.

2010 онд баталсан Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Базелийн хорооны “Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим”-д тулгуурлан боловсруулсан билээ. Тус хороог 1974 онд Бельги, Канад, Герман, Итали, Япон, Голланд, Швед, Швейцар, Их Британи, Америк зэрэг 10 гаруй улс хамтран байгуулсан бөгөөд эдүгээ нийт 27 орны гишүүнчлэлтэй боловч тогтоосон зарчим, бусад стандартыг нь дэлхийн 100-аад улс сайн дурын үндсэн дээр нэгдэж, хэрэгжүүлэхээ албан ёсоор зарлаад байгаа олон улсын байгууллага юм.

“Банкны үр ашигтай хяналт шалгалтын үндсэн зарчим” нь банкны хяналт шалгалтыг зохистой хэрэгжүүлэхэд шаардлагатай, нийтлэг хэрэглэгдэх суурь хэм хэмжээнээс бүрддэг. Үндсэн зарчмуудыг дээр дурдсанчлан дэлхийн ихэнх орнууд хэрэгжүүлэхийг зорьдог бөгөөд дотоодын болон олон улсын санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулахаас гадна хяналт шалгалтын үр дүнг сайжруулах үндэслэл болно.

Тус зарчмын 11-д “Холбогдох этгээдийн эрсдэл: Холбогдох этгээдтэй холбоотой санхүүгийн үүргээс (тэнцэл дээр болон тэнцлийн гадуурх) учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор хянан шалгагч нар банкнаас холбогдох этгээдэд зээл олгоход учирч болзошгүй эрсдэлийг тогтоох, түүнээс сэргийлэх, учирсан алдагдлыг холбогдох хэм хэмжээний дагуу тэнцлээс хасах талаар тавигдах шаардлагуудыг тогтоох нь зүйтэй.” гэж заасан байдаг.

Олон улсын туршлагаас харахад ихэнх улс орнууд “холбогдох этгээд”-ийн хүрээг Холдингийн тухай, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай зэрэг төрөлжсөн хуульдаа нарийвчлан тогтоосон байдаг бөгөөд ингэхдээ олон улсын нягтлан бодох бүртгэлийн болон аудитын стандартад заасан тодорхойлолтыг ашиглаж байна.



Монгол Улс олон улсын аудитын болон нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг албан ёсоор мөрдөж эхлээд тодорхой хугацаа өнгөрч байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх” шаардлага тавьдаг бол Аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Аудитын үйл ажиллагаанд аудитын олон улсын стандартыг мөрдөнө” гэж заасан байдаг.

Эдгээр стандарт тус бүрт “холбогдох этгээд” гэсэн ойлголтод тодорхойлолт өгсөн бөгөөд түүнд нийцүүлэн Банкны тухай хуульд “холбогдох этгээд”-ийн хүрээг тогтоосон билээ.

Банкны тухай хуулийг бүхэлд нь авч үзвэл “холбогдох этгээд”-тэй холбоотой зохицуулалт үндсэн 2 бүлэг асуудлыг хамарч байгаа. Үүнд:

1/Банкны тухай хуулийн 17 дугаар зүйл - Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалттай холбоотой бүлэг харилцаа /нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээл, баталгаа, батлан даалтын нийлбэр дүнд хязгаарлалт тогтоох асуудал/;

2/Мөн хуулийн 36 дугаар зүйл - банкны хувьцаа эзэмшигч дангаар болон холбогдох этгээдтэй хамтран нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болсон үед тэдгээрийн хувьцаагаа захиран зарцуулах эрхийг хязгаарлахтай холбоотой бүлэг харилцаа.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хувьд дараах асуудлыг хамарч байгаа. Үүнд:

1/Хуулийн 10 дугаар зүйл - үнэт цаас гаргагчийн танилцуулгад холбогдох этгээдийн талаар тусгах шаардлага;

2/Хуулийн 22 дугаар зүйл - Компанийн хувьцааг худалдан авах санал гаргахад компанийн хувьцаа эзэмшигч, хяналтын багц эзэмшигч, тэдгээрийн холбогдох этгээдэд тавих шаардлага;

3/Хуулийн 53 дугаар зүйл - холбогдох этгээд нь зохицуулалттай этгээдийн аудитороор ажиллахыг хориглох тухай асуудал;

4/Хуулийн 56 дугаар зүйл - үнэт цаас гаргагч нь холбогдох этгээдийн мэдээллийг нийтэд мэдээлэх тухай зохицуулалт.

Дээр дурдсан бүлэг зохицуулалт нь Монголбанкны болон Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалтын талаар эдгээр хуулиудад орсон хэм хэмжээг хэрэглэх, тухайн этгээдийн өмчлөл хэт монополь байдалтай болж, салбарын өрсөлдөөнийг хязгаарлахаас



сэргийлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийг хамгаалах, мэдээллийг нийтэд ил тод болгох зэрэг шаардлагыг хангасан байх, ингэснээр тухайн зах зээлд итгэх олон нийтийн итгэлийг бий болгох, нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, харилцагч, иргэдийн эрх ашиг хохирохоос сэргийлэх суурь үндэслэл болж байгаа юм.

Иймд Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Банк, санхүү, үнэт цаасны зах зээл нь төрөөс мэргэжлийн онцгой хяналт, зохицуулалт шаарддаг учраас тухайн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, үнэт цаасны зах зээлийн хурдацтай хөгжил, өөрчлөлт, онцлогийг харгалзан үнэт цаасны зах зээлийн оролцогч, банкны харилцагчийн эрх ашгийг хамгаалах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авах зорилгоор хянан зохицуулагч байгууллагад тодорхой эрх олгож болохоор олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн банк, санхүүгийн салбарын хяналт, шалгалтын үндсэн зарчмуудад тусгасан байдаг бөгөөд дээрх зарчим болон олон улсын стандартуудыг манай улсын банк, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаандаа удирдлага болгохоор холбогдох хууль тогтоомжид тусгасан гэж үзэхээр байна.

2. Улс орны эдийн засагт банк, санхүүгийн салбарын гүйцэтгэх онцгой чиг үүрэг, олон улсын банк, санхүүгийн салбарын тогтолцооны харилцан нягт уялдаатай байдал зэргийг харгалзан Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж; Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалтад зааснаар хянан зохицуулах эрх бүхий байгууллага болох Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд “холбогдох этгээд”-ийг тодорхойлох эрх олгож хуульчилсан нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах,” гэх заалтыг тус тус зөрчсөн гэж үзэхээргүй байна.

3. Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо нь Улсын Их Хурлаас байгуулагддаг, ажлаа Улсын Их Хуралд шууд хариуцан тайлагнадаг байгууллага бөгөөд хэрэв эрх мэдлээ хэтрүүлсэн, хууль зөрчсөн, Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан шийдвэр гаргавал Монгол Улсын Их Хурлын



тухай хуульд зааснаар хууль зөрчсөн шийдвэрийг Улсын Их Хурал өөрөө хүчингүй болгох эрхтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН
ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2.ж дэх заалтад “Монголбанк холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.”; Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30.е дэх заалтад “Санхүүгийн зохицуулах хорооноос “холбогдох этгээд” гэж тодорхойлсон бусад этгээд.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн “... хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэх заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**П.ОЧИРБАТ
Ш.ЦОГТОО
Д.СУГАР
Д.НАРАНЧИМЭГ
Д.СОЛОНГО**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 3,25

Индекс: 14003